

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЖУРАМД НЭМЭЛТ ОРУУЛАХ ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХАД ХИЙСЭН НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ

1.Хавсралтад нэмэлт оруулах тухай Засгийн тогтоолын төсөл боловсруулах үндэслэл шаардлага

Засгийн газар нь Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6-т заасан “Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах журмыг Засгийн газар батална.” гэж хуульчилсан, Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны 30 дугаар тэмдэглэлээр “... хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр санал боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх”-ийг даалгаж шийдвэрлэжээ.

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэл, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т туссан “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэсэн үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийг байгуулах” гэж тус тус урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигт заасан байдаг.

Хөгжлийн бодлогын баримт бичигт туссан хөгжлийн төслийн хөрөнгө оруулалт, төслийн онцлог, цар хүрээ, шинж чанар, бэлтгэгдсэн бэлэн байдлаас хамаарч хөрөнгө оруулагч, гүйцэтгэгч этгээдтэй хамтран ажиллах Хөрөнгө оруулалтын талаарх санал, санхүүжилтийн хувилбар, техник технологийн шийдэл, төсөвт нөлөөлөх эдийн засгийн нөлөөлөл зэрэг харилцан адилгүй байгаагаас хамаарч хөгжлийн зарим төслийг хэрэгжүүлэх асуудал удаашрах зэрэг хүндрэл бэрхшээл гарч байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохицуулах тухай хууль, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиар тогтоомжоор зохицуулагдах боломжгүй, 500 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хөгжлийн төслийг хөдөлгөх, хөрөнгө оруулагчтай урьдчилсан хэлэлцээ хийх зэргээр Хөгжлийн төслийн хөрөнгө оруулалтын бэлтгэл арга хэмжээг Хөрөнгө оруулалтын тухай хуульд нийцүүлэн Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах журмын нарийвчилсан зохицуулалтыг нэмж тусгалаа.

Журамд дараах зохицуулалтыг нэмж тусгалаа.

1.“Хөгжлийн бодлогын баримт бичигт туссан хөгжлийн төслийг шууд хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхэд дотоод болон гадаадын хөрөнгө оруулагчдад нээлттэй санал хүргүүлэх, боломжит хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах арга хэмжээг зохион байгуулах зохицуулалт;

2.Төслийн урьдчилсан нөхцөл, төслийн талаар нээлттэй санал хүргүүлэх, сонирхсон хөрөнгө оруулагчдын саналыг хүлээн авах, судалж, танилцуулах арга хэмжээг Засгийн газраас эрх олгосон дагуу холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулсан Ажлын хэсэг хариуцан зохион байгуулна. Шаардлагатай тохиолдолд мэргэжлийн зөвлөх үйлчилгээ авч болох арга хэмжээ;

3.Төслийн онцлог, хэрэгцээ шаардлага, бусад нөхцөлийг харгалзан боломжит хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах, урьдчилсан яриа хэлэлцээ хийх хүрээ хязгаарыг Засгийн газар тогтоох зэрэг зохицуулалтыг нэмж тусгалаа.

2.Журмын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохицуулах тухай хууль, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиар тогтоомжоор зохицуулагдах боломжгүй, 500 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хөгжлийн төслийг хөдөлгөх, хөрөнгө оруулагчтай урьдчилсан хэлэлцээ хийх зэргээр Хөгжлийн төслийн хөрөнгө оруулалтын бэлтгэл арга хэмжээг Хөрөнгө оруулалтын тухай хуульд нийцүүлэн Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах журмын нарийвчилсан зохицуулалтыг энэхүү журамд нэмж тусгалаа.

Уг журамд нэмэлт оруулах нөлөөллийн шинжилгээг хийж гүйцэтгэхдээ Хууль зүйн сайдын 2018 оны А/147 дугаар тушаалаар батлагдсан Нөлөөллийн шинжилгээний аргачлалын дагуу хийж гүйцэтгэлээ.

Журмын 1 дэх хэсэгт “1.4.Хөгжлийн бодлогын баримт бичигт туссан хөгжлийн төслийг шууд хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхэд дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчдад нээлттэй санал хүргүүлэх, боломжит хөрөнгө оруулагчийг урьдчилсан байдлаар сонгон шалгаруулах арга хэмжээг журмын 1¹.1-д заасан Ажлын хэсэг зохион байгуулж болно.” гэсэн зохицуулалтыг нэмж тусгалаа.

Журмын бүлэгт 1 дүгээр бүлэг “Нийтлэг үндэслэл” гэсэн бүлгийн дараа “1¹.Хөгжлийн төслийн хөрөнгө оруулалтын бэлтгэл арга хэмжээ” гэсэн зүйлийг нэмж тусгалаа.

3.Журмын төсөл батлагдсаны дараа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа бүлэг

Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах журамд нэмэлт оруулах Засгийн газрын тогтоол **батлагдсанаар дараах 3 бүлгийн ашиг сонирхол хөндөгдөнө.**

Үүнд:

1. Хөрөнгө оруулагч аж ахуй нэгж;
2. Засгийн газраас эрх олгосон Ажлын хэсэг;
3. Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;

Энэхүү журамд нэмэлт оруулах тухай Загсийн газрын тогтоол батлагдан гарснаар дотоод, гадаадын хөрөнгө оруулах сонирхолтой хувь хүн, хуулийн этгээд, хөрөнгө оруулалт асуудал эрхэлсэн атөрийн захиргааны байгууллага, төрийн захиргааны төв байгууллага, төсөл хэрэгжүүлэх орон нутгийн иргэдийн хууль ёсны эрх ашигт сөргөөр нөлөөлөхгүй бөгөөд Хөгжлийн төслийг шууд хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх боломж бүрдэх болно.

4.Хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад, хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт, агуулга байгаа эсэх

Хөгжлийн бодлогын баримт бичигт туссан хөгжлийн төслийг хэрэгжүүлэх, хамтран ажиллах, хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах, хөрөнгө оруулалтын

гэрээ байгуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох журамд нэмэлт оруулах тухай Засгийн газрын тогтоол батлагдсанар төрийн захиргааны байгууллага, хуулийн этгээдэд үзүүлэх эерэг нөлөөллийг хууль ёсны эрх ашиг сонирхол нь хөндөгдөхөөр тогтоогдсон 3 бүлэг тус бүрээр үзүүллээ.

Үүнд:

Нөлөөлөл/бүлэг	Төрийн захиргааны байгууллага /төв байгууллага/:	Хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжүүд	Төсөл хариуцан хэрэгжүүлэгч этгээд
Эерэг нөлөөлөл	- Хөгжлийн бодлогын баримт бичигт дурдсан хөгжлийн төслийг хэрэгжүүлэх боломж бүрдэнэ. - Улсын төсөвт дарамт учруулахгүй байдлаар хөгжлийн төслийг шууд хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлэх боломж бүрдэнэ. - Олон улсад хөрөнгө оруулагч сонирхогч этгээдэд нээлттэй санал хүргүүлснээр бусдад давуу байдал үүсэх болож үүсэхгүй. - Хөгжлийн төсөлтэй холбоотой мэдээлэл ил тод нээлттэй болсноор тухайн чиглэлээр судалгаа шинжилгээ хийх мэдээлэл боловсруулалт хийхэд хялбар болсон. - Урьдчилсан байдлаар хөрөнгө оруулж, хамтран ажиллах саналыг нэг этгээд бус Засгийн газрын эрх олгосон Ажлын хэсэг судлан Засгийн газрын хуралдаанаар хамгийн сайн гэж	- Үйлдвэрт шаардлагатай түүхий эдийн тогтвортой нийлүүлэлт баталгаажна. - Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан тогтворжуулах гэрчилгээ авч, Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулснаар татварын тогтвортой таатай орчин бүрдэнэ. - Дэд бүтцийн хувьд авто зам, төмөр зам, ариутгах татуурга, цахилгаан хангамж бүрэн шийдэгдсэн. - Үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэх төслийн талбайг Засгийн газрын шийдвэрээр улсын тусгай хэрэгцээнд авсан. - Аж ахуй нэгжийн орлогын албан татвар, Нэмэгдсэн өртгийн албан татвар, Ашигт малтмалын нөөц ашигласны албан татварыг 15-18 жилийн	- Төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалт санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхэд өөрт болон төсөвт дарамт учруулахгүйгээр шийдвэрлэх боломжтой. - Технологийн хувьд байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай, дэвшилтэт технологийг Хөрөнгө оруулагч талтай хамтран зөвшилцөн технологи сонголтыг шийдлийг тодорхойлж эрсдэлийг харилцан үүрэг боломж бүрдэнэ. - Урт хугацаанд үйлдвэрийн хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай инженер техникийн ажилчдыг хөрөнгө оруулагч, хамтран ажиллагч

	үнэлэгдэхүйц хүртэлх тооны хөрөнгө оруулагчдийн саналыг танилцуулж, хамгийн сайж гэж үзсэн этгээдтэй Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах боломж бүрдэнэ. - Хураангуй жагсаалт үүсгэх Ажлын хэсгийн гишүүдийг эрх бүхий байгууллагаас томилох тул Хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах гишүүдэд нөлөөлөх боломж багасна. - Аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй үл ойлголцол гарах эрсдэлийг бууруулсан.	хугацаанд тогтворжуулна. - Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан татварын болон татварын бус дэмжлэг авна. Тухайлбал: Гаалийн албан татвар 5 жилийн хугацаанд чөлөөлнө, Газрын төлбөрийг чөлөөлнө, дэд бүтэц, үйлдвэрийн бүтээн байгуулалтад шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн НӨАТ-ын татварыг тодорхой хугацаагаар хойшлуулна, гадаад ажилтын ажлын байрны төлбөрөөс чөлөөлнө, хөнгөвчлөх горимоор ажиллах хүч оруулах боломж бүрдэнэ, эцсийн бүтээгдэхүүний НӨАТ-ын - Ойлгомжгүй байдлаас цаг хугацаа алдах эрсдэлийг бууруулсан.	этгээдийн боломжоор сурган бэлтгэх боломж бүрдэнэ. -
	- Төрийн захиргааны байгууллага нь холбогдох хуулийн хүрээнд өмнө гүйцэтгэж байсан эрх үүргээ биелүүлэх бөгөөд түүний эрх	- Хөрөнгө оруулагч, сонирхогч этгээд, түүний эрх ашгийг хөндсөн үйлдэл байхгүй төдийгүй сөрөг үр дагавар байхгүй болно.	- сөрөг үр дагавар байхгүй болно.

Сөрөг нөлөөлөл	ашгийг хөндсөн үйлдэл байхгүй төдийгүй сөрөг үр дагавар байхгүй болно.		
Дүгнэлт	-Хөгжлийн бодлогын баримт бичигт туссан хөгжлийн төслийн хөрөнгө оруулалт, төслийн онцлог, цар хүрээ, шинж чанар, бэлтгэгдсэн бэлэн байдлаас хамаарч хөрөнгө оруулагч, гүйцэтгэгч этгээдтэй хамтран ажиллах Хөрөнгө оруулалтын талаарх санал, санхүүжилтийн хувилбар, техник технологийн шийдэл, төсөвт нөлөөлөх эдийн засгийн нөлөөлөл зэрэг харилцан адилгүй байгаагаас хамаарч хөгжлийн зарим төслийг хэрэгжүүлэх асуудал удаашрах зэрэг хүндрэл бэрхшээлгүй нөхцөл байдал арилна. Хөгжлийн бодлогын баримт бичигт туссан зарим хөгжлийн төслийг шууд хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, төслийн онцлог, цар хүрээ, шинж чанар, бэлтгэгдсэн байдал зэргийг харгалзан тэдгээрийн татан оролцуулах, хамтран ажиллах саналыг харгалзан зохистой хөрөнгө оруулагчдийн хураангуй жагсаалтыг үүсгэх зэрэг зарим тодорхой зохицуулалт тусгагдаагүй байсан харилцаа тодорхой болно. Хөгжлийн бодлогын баримт бичигт хөгжлийн төслийг хөдөлгөх, эрчимжүүлэх, хөрөнгө оруулагчтай урьдчилсан хэлэлцээ байгуулах, хөрөнгө оруулалт татах зэрэг арга хэмжээг зохион байгуулах эрх зүйн орчин сайжирч, боломж бүрдэх юм. Төрийн байгууллага болон аж ахуйн нэгж байгууллагад захиргааны шинж чанартай нэмэлт ачаалал бий болгохгүй, хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөхгүй болно.		

Журамд нэмэлт оруулах Засгийн газрын тогтоол батлагдсанаар Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан урт, дунд болон богино хугацааны бодлогод туссан хөгжлийн төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхэд шаардлагатай Хөрөнгө оруулагчийг сонгох, түүнтэй хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах эрх зүйн орчин сайжрах юм.

Мөн хөгжлийн төслийн онцлог, цар хүрээ, бэлэн байдлын зэргийг харгалзан сонирхогч этгээдүүдэд нээлттэй санал хүргүүлэх, боломжит оролцогчийн хураангуй жагсаалт гарган эрх бүхий этгээдэд танилцуулж, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах этгээдийг тодорхойлох боломж бүрдэх бөгөөд Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050”, Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт туссан “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төсөл барина” гэж заасныг хэрэгжүүлэх боломж бүрдэж, нийгэм-эдийн засагт өндөр ач холбогдолтой.

Хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад, хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт, агуулга байхгүй болно.

5.Тухайн асуудлыг зохицуулж байгаа хүчин төгөлдөр хууль, захиргааны хэм хэмжээний акт байгаа эсэх

Хөрөнгө оруулалтын тухай хууль болон Засгийн газрын 2014 оны 52 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах журам” хүчин төгөлдөр үйлчилж байгаа бөгөөд тухайн журамд нэмэлт оруулахаар “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулаад байна.

6.Актыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, техник, эдийн засгийн тооцоо

Журамд нэмэлт оруулах Засгийн газрын тогтоол батлагдсантай холбогдуулан шинээр төрийн байгууллага байгуулах, эсвэл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийгдэх, захиргааны шинэ чиг үүрэг бий болгох шаардлагагүй бөгөөд мөн тухайн шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдон аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд хүний нөөц болон техник эдийн засгийн зардал үүсэхгүй.

Журамд “1¹.1.Журмын 1.4-т заасан хөгжлийн бодлогын баримт бичигт туссан хөгжлийн төслийг шууд хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхэд Засгийн газрын эрх олгосон холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулсан Ажлын хэсэг байгуулна.” гэсэн зохицуулалтыг нэмж тусгаж байгаа бөгөөд тус зохицуулалтын дагуу ажлын хэсгийн гишүүд нь тухайн байгууллагын ажилтан, албан хаагч нар өөрсдийн хариуцсан чиг үүргийн дагуу ажлын хэсэгт гишүүнээр оролцох учраас ажлын хэсгийг байгуулахтай холбоотой ямар нэг байдлаар нэмэлт зардал гарахгүй болно.

“1¹.2.Журмын 1¹.1-д заасан Ажлын хэсэг нь хөгжлийн төслийн цар хүрээ, онцлог, хэрэгцээ шаардлага, бэлэн байдлын зэрэг нөхцөл байдалд тулгуурлан гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид санал хүргүүлж, ирүүлсэн саналыг судлан хамгийн ашигтай гэж үзэхүйц 5 хүртэлх оролцогч этгээд, Хөрөнгө оруулагчдын саналыг хувилбарыг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, хэлэлцүүлнэ.”;

“1¹.3.Төслийн цар хүрээ, онцлог, хэрэгцээ шаардлага, бусад шаардлагатай нөхцөл байдлыг харгалзан боломжит хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах, урьдчилан яриа хэлэлцээ хийх, журмын 2.1-д заасан Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хүсэлт гаргах хүртэл хугацаанд хөрөнгө оруулагчтай зөвшилцөх хүрээ хязгаарыг Засгийн газар тогтооно.” энэхүү зохицуулалтаар тус тус хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах бэлтгэл ажлын зохион байгуулалт, урьдчилсан яриа хэлэлцээ хийхтэй холбоотой харилцааг зохицуулсан.

Түүнчлэн гадаад, дотоодын хөрөнгө оруулагч нар хөрөнгө оруулалтын талаарх саналаа ирүүлэхдээ ямар нэг нэмэлт зардал гарахгүй, урьдчилсан яриа хэлэлцээ хийхэд мөн адил нэмэлт зардал гарахгүй болно.

АЖЛЫН ХЭСЭГ